



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар

A/709.

Ховд

Аэродромын аюулгүйн бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.7 дахь заалтууд, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/131 тоот тушаалаар батлагдсан “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” технологийн баримт бичгийн 7.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын нутагт орших Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа “Ховд” нисэх буудлын аэродромын аюулгүйн бүс болох “Тусгай бүс”, “Агаарын хөлгийн ойртолтын бүс” аэродром орчмын “Аюулгүйн А болон Б бүс”-ийн зургийг нэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Аэродромын аюулгүйн “Тусгай бүс” буюу агаарын хөлгийн буулт, хөөрөлтийн чиглэлд хөөрч буух зурвасны босгоос хоёр тийш 4000 метр урт, хөөрч буух зурвасны тэнхлэгээс хоёр тийш 1000 метр буюу нийт 2000 метрийн өргөнтэй тэгш өнцөгт талбайд газар олгохгүй байх, өмнө олгосон газарт барилга байгууламж барих тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газар, Нисэх буудалтай урьдчилан зөвшилцөж, нисэхийн аюулгүй байдлыг хангасан шийдвэр гаргаж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

3. Аэродромын орчмын “Аюулгүйн А болон Б бүс”-д иргэн, аж ахуйн нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нь “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичгийн 7.5.1-ийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Жаргалант сумын засаг дарга /Ц.Цогтбаяр/, “Ховд” нисэх буудлын дарга /Г.Жаргал/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/199 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Д.Энхболд/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, “Ховд” нисэх буудлын дарга /Г.Жаргал/-д тус тус үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА







Б.ДҮГЭРЖАВ

02 2193
d/Zah-A/709-Bo

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр 23-ны өдрийн А/709 дугаартай
захирамжийн хавсралт



Тайлбар:

- | | |
|--|---|
|  Тусгай бүс |  Агаарын хөлгийн ойртолтын бүс |
|  "А" БҮС |  "Б" БҮС |

Зураг 7.5-1. Аэродром орчмын аюулгүйн бүс

